

СЭНДБОКС ЗОХИЦУУЛАЛТЫН ОРЧИН ГЭЖ ЮУ ВЭ?



Технологид суурилсан шинэ, шинэлэг санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээ, бизнес загварыг Зохицуулагч байгууллагын хяналт, зохицуулалт дор хязгаарлагдмал хүрээ, бодит орчинд, тодорхой цаг хугацаанд туршихыг хэлнэ.

СЭНДБОКСЫН ОРОЛЦОГЧДОД ТАВИГДАХ ШААРДЛАГА

- ✓ Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд байх;
- ✓ Банк, санхүүгийн байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөргүй байх;
- ✓ Хувьцаа эзэмшигчид, удирдах түвшний албан тушаалтнууд өмнө нь мөнгө угаах болон эдийн засгийн гэмт хэрэгт ял шийтгэлгүй;
- ✓ Хувьцаа эзэмшигчийн оруулж буй хувь хөрөнгө нь Мөнгө угаах, терроризмийг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан шаардлагыг хангасан;





Сэндбоксын бүтээгдэхүүн, үйлчилгээ нь дараах шаардлагыг хангасан байна

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх чиглэлд ашиглагдах зорилго агуулаагүй;

Хэрэгжих боломжтой ба техник, эдийн засгийн үндэслэл, санхүүгийн үр ашгийн тооцоо хийгдсэн;

Сэндбоксын хугацаанд үйл ажиллагаа явуулах, үүсэж болзошгүй эрсдэлийг нөхөх санхүү, төлбөрийн чадамжтай байх;

Санхүүгийн үйлчилгээний хүртээмж болон хэрэглэгчдийн хүртэх үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн;

Санхүүгийн тогтвортой байдалд заналхийлээгүй;

Сэндбоксын хүрээнд хэрэглэгчдэд санал болгоход бэлэн болсон, технологийн хөгжүүлэлт нь шаардлагатай хэмжээнд хийгдсэн байх.

Тус журамд заасан технологийн шаардлагыг хангасан байх;

Санхүүгийн зах зээлд шинээр нэвтэрч байгаа эсхүл ижил төстэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээтэй харьцуулахад үр өгөөж өндөртэй, зардал багатай байх;